



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/07

Цагаан-Уул сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сум дундын эмнэлэгт авто машины сэлбэг авахад зориулж 1.130.000 (Нэг сая нэг зуун гучин мянган) төгрөг, Хөх тракторын сэлбэг худалдан авах зардалд 3.700.000 (Гурван сая долоон зуун мянган) төгрөг, Ковшны ир худалдан авахад 1.085.000 (Нэг сая наян таван мянган) төгрөг нийт 5.915.000 (Таван сая есөн зуун арван таван мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт зарцуулалтын дансанд орж ирсэн хандивын мөнгөнөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

3. Нягтлан бодох бүртгэлийн хууль, журмын дагуу санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нярав (Н.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ТҮМЭНБАЯР

